



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт,
үр дүн, үр ашиг

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018 он

АГУУЛГА

Аудитын нэр	1
Аудитын код	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
Аудитын зорилт	3
Аудитын хамрах хүрээ	3
Үндсэн мэдээлэл	3
Эрсдэлийн үнэлгээ	4
Аудитын арга зүй	4
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд	4
Аудитын хугацаа, тайланда тусгагдах мэдээлэл	5
Аудит хийх бүрэлдэхүүн	5
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц	5
Хавсралт 1. Эрсдэлийн үнэлгээ	
Хавсралт 2. Асуудлын шинжилгээ	
Хавсралт 3. Арга зүй	
Хавсралт 4. Аудитын хөтөлбөр	
Хавсралт 5. Аудитын үр өгөөжийн төлөвлөлт	
Хавсралт 6. Аудитын зардлын тооцоо	
Хавсралт 7. Дотоод албан томилолтын зардлын задаргаа	

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

БАТЛАВ.

Д.ХҮРЭЛБААТАР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

2. Аудитын код

ГАГ-2018-01-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуутиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитой тооцож, үнэлсэн эсэх.

5. Аудитын хамрах хүрээ

Аудитад улсын төсвөөс 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын 373 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг хамруулна.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн 354.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын хүрээнд Үндэсний аудитын газраас тусгайлан дүгнэлт гаргаж байгаа тул энэ аудитад концессын эдгээр, төсөл арга хэмжээг хамруулаагүй болно.

6. Үндсэн мэдээлэл

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хууль 2016 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-нд болон 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр тус тус нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2,503.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 373 төсөл, арга хэмжээнд 602.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгох, 2 дугаар хавсралтаар “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн 354.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 177.7 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийхээр баталсан байна. Нийт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад өмнөх оноос шилжиж ирсэн 343, шинээр эхлүүлэх 30 байна.

Улсын төсвийн хөрөнгийн санхүүжилтийн 28.4 хувийг боловсролын салбарт, 29.8 хувийг зам тээвэр, дэд бүтцийн салбарт, 17.7 хувийг барилгын салбарт, үлдсэнийг бусад салбарт зарцуулахаар тус тус хуваарилжээ.

7. Эрсдэлийн үнэлгээ

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дун шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв. (*Эрсдэлийн үнэлгээг хавсралт 1-ээс үзнэ үү.*)

8. Аудитын арга зүй

Аудитын гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДЬОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнууд, судлаачид, шинжээчидтэй ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дун шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дунд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна. (*Асуудлын шинжилгээг хавсралт 2, аудитын арга зүйг хавсралт 3-аас үзнэ үү*)

Аудитын төлөвлөлт нь аудитын туршид үргэлжлэх үйл ажиллагаа тул аудитын явцад хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн нэмэлт горим, арга зүйг тусган аудитын төлөвлөгөөнп нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Үндэсний аудитын газраас Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дун, үр ашигт хийх аудиттай зэрэгцэн аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрууд орон нутгийн төсвийн санхүүжсэн болон улсын төсвийн хөрөнгөөр Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд аудит хийж, бие даасан тайлан гаргана.

Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрууд Үндэсний аудитын газраас хүргүүлэх судалгааны маягт, тайлагналын загварын дагуу орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн аудитын судалгаа, үр дүнгийн мэдээллийг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 20-ны дотор ирүүлж, нэгтгүүлнэ.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийг нарийвчилсан шалгах зорилгоор аудитад зөвлөх, мэргэжлийн шинжээчийг татан оролцуулах бөгөөд холбогдох сонгон шалгаруулалтыг Үндэсний аудитын газарт Тамгын газар, орон нутагт аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар өөрсдөө зохион байгуулна.

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Барилгын тухай хууль,

- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Төрийн албаны тухай хууль,
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”,
- Олон улсын төсвийн түншлэлийн үнэлгээ¹
- Олон улсын ил тод байдлын хүрээлэнгийн үнэлгээ²
- Монгол улсын зээлжих зэрэглэл
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын судалгаа³

10. Аудитын хугацаа, тайланда тусгагдах мэдээлэл

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлж, аудитын талбарын ажлыг 2018 оны 2 дугаар сарын 12-ноос 3 дугаар сарын 30-ны өдрүүдэд гүйцэтгэх ба тайлагналыг үе шатыг 2018 оны 5 дугаар сарын 10-наас эхлүүлж, тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталгаажуулан 2018 оны 6 дугаар сарын 8-ны дотор УИХ-д хүргүүлнэ. (Аудитын хөтөлбөрийг хавсралт 4-өөс үзүүлж)

Аудитын тайланда дэвшүүлсөн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүп, дүгнэлт, зовломжоос гадна шалтагдагч байгууллагын саналыг тусгана.

11. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг ЯАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор М.Давааням хянан удирдаж, аудитын менежер Л.Эрдэнэчuluун аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Саруул, аудитор Ц.Цолмон, Б.Лхагвацэрэн, Б.Хаш-Эрдэнэ болон гэрээт ажилтнууд гүйцэтгэнэ.

12. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

а. Боловсон хүчин: ЯАГ: 4 хүн*149 өдөр = 596 хүн/өдөр
 Гэрээт ажилтан: 2 хүн*55 өдөр = 110 хүн/өдөр
 Зөвлөх 1 хүн*55 өдөр = 55 хүн/өдөр

б. Санхүүгийн нөөц:	Цалин	-	31.5 сая төгрөг
	Гэрээт ажилтан	-	6.4 сая төгрөг
	Зөвлөх	-	2.4 сая төгрөг
	Томилолт	-	4.9 сая төгрөг
	Лаборатори	-	60.0 сая төгрөг
	Бичиг хэрэг	-	1.0 сая төгрөг
	Шинжээчийн зардал	-	133.0 сая төгрөг
	Нийт	-	239.2 сая төгрөг

в. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл.

¹ www.internationalbudget.org

² www.transparency.org

³ www.oecd.org

Аудитын төлөвлөгөөг хянаж, зөвшөөрсөн:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

С.ОЮУНБИЛЭГ

Боловсруулсан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТИН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР 

М.ДАВААНЯМ

АУДИТИН МЕНЕЖЕР 

Л.ЭРДЭНЭЧУЛУУН

АХЛАХ АУДИТОР 

Б.САРУУЛ

АУДИТОР 

Б.ХАШ-ЭРДЭНЭ



Б.ЛХАГВАЦЭРЭН

2018 оны 2 дугаар сарын 06-ны одор

--00--

Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний өзүүлэлт, үр дүн, үр ашиг

А.Хөрөнгө оруулалтын төсөл,
арга хэмжээг хууль
тогтоомжид нийцүүлэн
үндэслэлтэй төлөвлөсөн үү?

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн болдогын
хүрээнд төлөвлөж байна уу?

А.2. Шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж,
багтуулсан үү?

А.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх
бэлтгэл хангагдсан байсан үү?

Б.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга
хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох
хууль, журмын дагуу зохион байгуулжсан үү?

Б.2.Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг үндэслэлтэй
боловсруулсан үү?

Б.3 Гүйцэтгэчийг байгууллага гэрээний үргээ хугацаанд нь
бурэн билгүүлсэн үү?

Б.4. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих
хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?

Б.5.Хөрөнгө оруулалтын болдого, Санхүү, төсвийн асуудал
эрхэлсэн төрийн байгуулалтын үйл ажиллагаа үр дүнтэй байна
үү?

В.Улсын төсвийн хөрөнгө
оруулалтын үр өгөөж, үр нөлөөг
бодитой тооцож, үнэлсэн үү?

В.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх
зорилт түвшин хангагдсан үү?

В.2.Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн гарын
дотоод хянгацт үр нөлөөтэй хэрэгжих байна үү?

В.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр нөлөөг
бодитой тооцож, үнэлсэн үү?

Асуудлын шинжилгээний 4 дэх түвшний асуудлууд

2 дахь түвшин	3 дахь түвшний асуулт	4 дэх түвшний асуулт
А.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжийд нийтийн төлөвлөсөн үү?	A.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөсөн үү?	A.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, салбарын бодлого, стратегитэй нийцэж байна уу? A.1.2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлуулах, өөрчлөлт оруулах үйл явцад төсвийн зарчим, хууль, журмаар тогтоосон шаардлагыг баримталж чадаж байна уу? A.1.3. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ ашиглагч байгууллагын хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн үү? A.1.4. Сангийн яам, ТЭЗ-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн үү?
	A.2. Шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан уу?	A.2.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхойгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан уу? A.2.2. ТЭЗҮ боловсруулагдсан, гарч болэх үр нэлөөг тооцсон, зураг, төсөлд нь магадлал хийгдсэн төсөл, арга хэмжээт хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан уу? A.2.3. Шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлүүдийг гаргуулсан уу? A.2.4. Он дамжин баригдах барилга, байгууламжийн зураг, төсөвт орсон өөрчлөлтөд дахин магадлал хийлгэж, баталгаажуулсан уу? A.2.5. Хөрөнгө оруулалтын шинж чанар тай бүс төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үү?
	A.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдсан байсан уу?	A.3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилгийг хэрэгжих хугацаатай уялдуулан тооцож, батлуулсан уу? A.3.2. Тухайн жилийн худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хугацаанд нь, тавигдах шаардлагын хэмжээнд боловсруулж, баталсан уу? A.3.3. Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний эрхийг боломжтой хугацаанд шилжүүлсэн үү?
	Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан уу?	Б.1.1. Төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтуудыг тавигдах шаардлагыг баримтлан боловсруулсан уу? Б.1.2. ТЭЗ үнэлгээний хороог зохих журмын дагуу байгуулж, тендерийн баримт бичгийг хугацаанд нь боловсруулсан уу? Б.1.3. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өр-өлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтын аргыг зөв сонгосон уу? Б.1.4. ТЭЗ худалдан авах ажиллагааны тайлант үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан уу?
	Б.2.Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг үндэслэлтэй боловсруулсан уу?	Б.2.1.Барилга, байгууламжийн зураг, төсвийг хэрэглэгчийн шаардлага, барилгын норм ба дүрэмд нийшүүлэн зохиосон уу? Б.2.2. Барилга, байгууламжийн төсөвт өргийг барилгын норм ба дүрмийн шаардлага, үнийн зохистой хэмжээг баримтлан тооцсон уу? Б.2.3. Барилгын зураг төсөл, төсөвт өөрчлөлт сруулах шаардлагатай тохиолдолд хугацаанд нь гүйцэтгүүлж, баталгаажуулсан уу? Б.2.4. Барилга, байгууламжийн зохиогчийн хяналтыг гэрээний үндсэн дээр чанартай хийж, хугацаанд нь тайлагнасан уу?

B. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитой тооцож, үнэлсэн үү?

<p>Б.3 Гүйцэтгэгч байгууллага гэрээний үргээ хугацаанд нь бүрэн биелүүлсэн үү?</p>	<p>Б.3.1. Гүйцэтгэгч байгууллага гэрээний үргээ хэрэгжүүлэх ажиллах хүчин, техник хэрэгслэлээр хангагдсан байсан уу? Б.3.2. Гүйцэтгэгч барилга, угсралтын ажлыг зураг, төсвийн дагуу, хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн үү? Б.3.3. Захиалагч, зохиогчийн хяналтаар илэрсэн зорчлийг тухай бурд нь арилгаагүйгээс үргүй зардал гаргасан уу? Б.3.4. Төсөл, арга хэмжээний санхүүжилтэй зориулалтын дагуу зарцуулсан уу?</p>
<p>Б.4. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?</p>	<p>Б.4.1. ТЕЗ гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд эрх, үүрэг, хариуцлагыг бүрэн тусгасан уу? Б.4.2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийээ тавих үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлсэн үү? Б.4.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хугацаанд нь бодитой хянаж, баталгаажуулсан уу? Б.4.4. Төсөл, арга хэмжээний урьдчилгаа болон ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн баримтыг зохих журмын дагуу бурдуулж, хугацаанд нь бүрэн олгосон уу? Б.4.5. Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайланг хугацаанд нь гаргаж, хүргүүлсэн үү? Б.4.6. Барилгын зураг төсөл, төсвийг зохиц шаардлагыг түвшинд боловсруулаагүй, хугацаа, чанарын шаардлага хангаж ажиллаагүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцсон уу?</p>
<p>Б.5. Хөрөнгө оруулалтын бодлого, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын үйл ажиллагаа үр дүнтэй байна уу?</p>	<p>Б.5.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх эрх зүйн орчинг шинэчлэх шаардлага байна уу? Б.5.2. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгоходо хууль, журамд заасан шалгуурыг үндэслэсэн үү?</p>
<p>B.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин хангагдсан уу?</p>	<p>B.1.1. Засгийн газар, ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилт, үр дүнг тооцож ажилласан уу? B.1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу?</p>
<p>B.2 Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?</p>	<p>B.2.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргэаны байгууллагын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих хяналт оновчтой, үр дүнтэй байна уу? B.2.2. ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт үр дүнтэй байна уу?</p>
<p>B.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг бодитой тооцож, үнэлсэн үү?</p>	<p>B.3.1. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг төлөвлөх, тооцож эрх зүйн орчин бүрдсэн үү? B.3.2. Хөрөнгө оруулалтаас бий болох үр өгөөжийг арга хэмжээ бүрээр тооцож, үр ашигтай хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн үү? B.3.3. Хөрөнгө оруулалтын бодит үр өгөөж төлөвлөсөн хэмжээнд хүрч чадсан уу? B.3.4. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төсөвт өргийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж, үрэлгэн төсвөөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн үү?</p>

Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга х